

Агуулга

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1 Төслийн нэр.....	3
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	3
1.3 Төслийн хүчин чадал	3
1.4 Уурхайн нөөц.....	4
1.5 Уурхайн ашиглалтын систем.....	4
1.6 Төслийн талбайн дэд бүтэц.....	5
1.7 Цахилгаан хангамж	6
1.8 Усан хангамж.....	6
1.9 Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам	7
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ	8
2.1 Төслийн талбайн байршил.....	8
2.2 Төсөл хэрэгжих талбайн өнөөгийн төлөв байдал	10
2.3 Төсөл хэрэгжих талбайн газрын гадарга	10
2.4 Төсөл хэрэгжих талбайн газаргын налуу.....	11
2.5 Төслийн талбайн физик газарзүйн нөхцөл.....	11
2.6 Төслийн талбайн хөрсөн бүрхэвч	12
2.7 Төслийн талбайн ургамлан нөмрөгийн хэв шинж	14
2.8 Нийгэм эдийн засаг.....	15
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	17
Агаарын чанар:.....	17
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	24
Нийт	24
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	25
БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	28
БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	28
БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	29
БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	29

БҮЛЭГ 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	29
БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	30
БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	31
БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	33
БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ.....	34

Хүснэгт

Хүснэгт 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	3
Хүснэгт 2 Ил уурхайн уулын ажлын хэмжээ	3
Хүснэгт 3 Далд уурхайн уулын ажлын хэмжээ	3
Хүснэгт 4 Уурхайн барилга байгууламж	5
Хүснэгт 5 Төслийн талбайн солбицол.....	8
Хүснэгт 6 Төслийн болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим	21
Хүснэгт 7 Нөлөөллийн эрчим, цар хүрээ, шинж чанараар ангилсан байдал	22

График

График 1 Баян сумын хүн амын хүйсийн бүтэц.....	15
График 2 Баян сумын төрөлтийн тоо, хүйсээр	15
График 3 Малын сүргийн бүтэц	16

Зураг

Зураг 1 Хүдэр хоршоолох ашиглалтын систем	5
Зураг 2 Худгийн байршил	7
Зураг 3 Төслийн талбайн сансарын зураг	8
Зураг 4 Төслийн талбайн байршилын зураг	9
Зураг 5 Газрын гадаргын өнөджилтийн зураг	10
Зураг 6 Төсөл хэрэгжих талбайн налуужилтын зураг	11
Зураг 7 Байгалын бүс бүслүүрийн зураг	12
Зураг 8 Төслийн талбайн хөрсөн бүрхэвч	13
Зураг 9 Төслийн талбайн ургамлан бүрхэвч	14
Зураг 10 Нөлөөллийн эрчмийн зураг	17

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр

“Мааньт уул” хайлуур жоншны ордыг ил болон далд аргаар ашиглах төсөл.

Төслийн зорилго: “Маань-Уул” хайлуур жоншны ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглаж эдийн засгийн эргэлтэд оруулахад оршино.

1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Хүснэгт 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Галзоо хан” ХХК
Төслийн нэр	“Мааньт уул” хайлуур жоншны орыг ил болон далд аргаар ашиглах төсөл
Улсын бүртгэлийн дугаар	9011115093
Регистрийн дугаар	5162696
Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-021694
Хаяг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 2-р хороо Хан-Уул цамхаг 907 тоот
Утас	77112428

1.3 Төслийн хүчин чадал

Ил уурхайн хүчин чадал: “Мааньт уул” ордыг ашиглалтын эхний 2 жилд ил аргаар олборлох бөгөөд 1-р жилд IIa, IIb хүдрийн биетүүдийг ил аргаар ашиглан 39.0 мян.м3 хөрс хуулж, 17.8 мян.тн хүдэр олборлохоор төлөвлөсөн байна.

Хүснэгт 2 Ил уурхайн уулын ажлын хэмжээ

Ашиглалтын жилүүд	Хүдэр олборлолт		Дундаж агуулга	CaF2-ийн хэмжээ	Хоосон чулуулаг	Хөрс хуулалтын коэффициент
	м3	тн	%	тн	м3	м3/тн
1-р жил	5,006.0	13,766.6	39.9	5,492.5	32,506.0	2.36
2-р жил	1,498.0	4,119.6	40.5	1,669.7	6,529.0	1.58
Дүн	6,504.06	17,886.17	40.04	7,162.20	39,034.94	2.18

Далд уурхайн хүчин чадал: Мааньт уулын хайлуур жоншны ордод уурхайн ашиглалтын 2-р жилээс 1-р далд уурхай (IIб хүдрийн биет) буюу +1400 түвшинд олборлолтын ажил түрүүлж явагдах бөгөөд 3-р жилд 2-р уурхайн (IVб хүдрийн биет) үндсэн болон бэлтгэл малталтууд нэвтэрч, нураалтын ажил явагдана.

Хүснэгт 3 Далд уурхайн уулын ажлын хэмжээ

Ашиглалтын жилүүд	Хүдэр олборлолт		Дундаж агуулга	CaF2-ийн хэмжээ	Хоосон чулуулаг
	М ³	тн	%	М ³	тн
2-р жил	2,309.8	6,352.0	31.4	1,997.2	2,519.8

“ГАЛЗОО ХАН” ХХК-ИЙН ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН НУТАГТ ОРШИХ “МААНЬТ УУЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3-р жил	3,035.6	8,347.9	38.2	3,187.7	3,377.3
Дүн	5,345.44	14,699.97	35.27	5,184.81	5,897.04

1.4 Уурхайн нөөц

“Мааньт уул”-ийн хайлуур жоншны ордын нийт нөөцийг 42,346.08тн хүдэр, үүнээс бодитой (В) нөөцийг 6528.63 тн эрдэс агуулсан 15,147.68 тн хүдэр, боломжтой (С) нөөцийг 11,562.41 тн эрдэс агуулсан 27,198.4 тн хүдэр тус тус тогтоож Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 11 дугаар сарын 19-ний Дугаар ХХ-17-06 тоот дүгнэлт, Ашигт малтмалын газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 17-ний өдрийн Дугаар н/09 тоот тушаалаар Монгол улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.


1.5 Уурхайн ашиглалтын систем

“Галзоо хан” ХХК өөрсдийн эзэмшлийн тоног төхөөрөмжүүдийг ашиглан шууд олборлолт явуулах үүднээс компанийн техникийн даалгаврын дагуу IV болон IIб хүдрийн биетүүдийг газрын гадаргаас дунджаар 6м гүнтэй гарш хэсгийг ил аргаар, үлдсэн хэсгийг далд аргаар ашиглана. Харин IIа, IIв хүдрийн биетүүд нь хоорондоо зэргэлдээ 3-15 м зайд байрлаж байна. Иймд компанийн техникийн даалгаврын дагуу зэргэлдээ байрлах IIа, IIв хүдрийн биетүүдийг бүхэлд нь ил аргаар олборлохоор тооцсон байна.

Ил уурхайн ашиглалтын систем: “Мааньт-Уул” хайлуур жоншны орд нь хүдрийн биетүүдийн газрын гадаргад ил гарсан гарштай ба ордын геологийн тогтоц, хөрсний чулуулгийн физик-механикийн шинж чанар, олборлолтын арга, механикжуулалтын бүтэц, тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт зэргийг харгалзан экскаватор-автосамосвалын хослол бүхий автотээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглахаар төлөвлөсөн байна.

Далд уурхайн ашиглалтын систем: Ордын уул-геологи, уул-техникийн нөхцөл, түүнчлэн ижил төстэй ордуудыг ашиглаж байгаа дэлхийн бусад улс орнуудын практик туршлага зэргийг үндэслэн хүдэр хоршоолохашиглалтын системээр олборлохоор төлөвлөсөн байна.

“ГАЛЗОО ХАН” ХХК-ИЙН ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН НУТАГТ ОРШИХ “МААНЬТ УУЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 1 Хүдэр хоршоолох ашиглалтын систем

1.6 Төслийн талбайн дэд бүтэц

Барилга байгууламж: Уурхайн барилга байгууламжид захиргааны байр, ажилчдын болон хоолны байр, агуулах-засварын байр багтана.

Хүснэгт 4 Уурхайн барилга байгууламж

№	Нэр	Хийц, бүрдэл	Тоо, м2
1	Босоо гол ам	Малталт	
2	Туслах ам	Малталт	
3	Засвар механикийн хэсэг	Сэндвич	80 м2 x 1
4	Сэлбэг, материалын агуулах	контейнер	40 тн x 1
5	Түлшний агуулах	ёмкость	60м3 x 2
6	Тэсэлгээний материалын агуулах	контейнер	40 тн x 1
7	Харуул хамгаалалтын байр	Сэндвич	20 м2 x 2
8	Оффис	контейнер	28 м2 x 2
9	Амрах байр	контейнер	28 м2 x 4
10	Амралтын байр	контейнер	28 м2 x 1
11	Гал тогоо	контейнер	28 м2 x 2

1.7 Цахилгаан хангамж

Төв аймгийн Баян сумын нутагт орших “Мааньт уул” хайлуур жоншны уурхайн цахилгаан хэрэглэгчидийг дараах байдлаар ангилж хуваалаа.


- Ил уурхай
- Далд уурхай
- Бутлах хэсэг
- Засварын хэсэг
- Захиргааны хэсэг
- Амрах байр
- Аж ахуйн хэсэг
- Гал тогоо

Ордын цахилгаан хангамжийг хангах зорилгоор төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс УБТЗ-ын УБ-Чойр 6 кВ-ийн нэгдсэн ЦДАШ-аас Мааньт уул уурхай руу 6 кВ-ийн 7 км шугам татан ажиллахаар төлөвлөж байна.

1.8 Усан хангамж

Уг орд дээр хийсэн хайгуулын ажлын явцад, өрөмдсөн цооногуудад ус агуулсан хурдас илрээгүй бөгөөд цаашдаа уурхайн олборлолтын ажилд гүний усны нөлөөлөх нөлөөгүй байна. Ордын хайгуулын ажлын гидрогеологийн судалгаагаар 30-60 метрийн гүнд газрын доорх усны түвшин илрээгүй байна. “Галзуу хан” ХХК нь Төв аймгийн Баян сумын нөөцөд байдаг Өгөөмөр 2-р багийн нутагт орших/46057144.9II, 107048154.3II/“Цагаан дэл” нэртэй 1.5 л/с худгаас унд ахуй болон хэрэглээний ус авахад татгалзах зүйлгүйг тодорхойлсон албан бичгийг Төв аймгийн Баян сумын засаг даргаас 2023 оны 07 сарын 07 -ны өдөр 1/144 тоотор авсан байна. Тухайн худаг нь төслийн талбайгаас зүүн урагш 3км-ийн зайд байрладаг байна. Худгын мэдээлэл:

- Өрөмдмөлгүний худаг
- Усны ундарга 1.5 л/сек
- Худаг координат -(46057144.9II, 107048154.3II)



Зураг 2 Худгийн байршил

1.9 Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам

“Мааньт-уул” хайлуур жоншны ордоос олборлох хүдрийг Чойр хотод байрлах үйлдвэрт нийлүүлэх бөгөөд ордоос 70 км-ийн зайд байрлана. Уурхайгаас олборлосон хүдрийг ZL50F загварын утгуурт ачигчаар 25 тн-ын даацтай HOWO маркын автосамсовалд ачин уурхайгаас ачин уурхайгаасбаяжуулах үйлдвэр хүртэл тээвэрлэнэ. Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн замыг Баян сумын засаг даргаар батлуулж гэрээ байгуулсан. Тээвэрлэлтийн зам нь Баян сумын нутаг дэвсгэр дээр 29.61 км байгаа бөгөөд үнээс 8.81 км нь шороон зам байна. Засгийн газрын 2018 оны 379-р тогтоолын дагуу Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглалтын журам-ын 2-р хэсэгт заасанчланхатуу хучилттай болгохыг зөвлөж байна.


БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төслийн талбайн байршил


“Мааньт уул” хайлуур жоншны орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 160 км, Төв аймгийн Зуунмод хотоос зүүн урагш 150 км, Мааньт төмөр замын өртөөнөөс 30 км, Чойр хотоос 70 км, харин Баян сумаас Зүүн урагш 20-иод км зайд тус тус байрлана. 1:100000-ны масштабтай планшетийн L-48-48 хавтгайд оршино.

Хүснэгт 5 Төслийн талбайн солбицол

№	Уртраг	Өргөрөг
1	107° 47' 30.67"	46° 59' 50"
2	107° 47' 16.5"	46° 59' 50"
3	107° 47' 16.5"	46° 59' 37.39"
4	107° 46' 40.67"	46° 59' 37.39"
5	107° 46' 40.67"	46° 59' 32.99"
6	107° 47' 16.5"	46° 59' 32.99"
7	107° 47' 16.5"	46° 59' 20.06"
8	107° 47' 30.67"	46° 59' 20.06"
9	107° 47' 30.67"	46° 59' 13.18"
10	107° 47' 52.04"	46° 59' 13.18"
11	107° 47' 52.04"	46° 59' 37.39"
12	107° 47' 30.67"	46° 59' 37.39"



Зураг 3 Төслийн талбайн сансарын зураг




Зураг 4 Төслийн талбайн байршилын зураг

2.2 Төсөл хэрэгжих талбайн өнөөгийн төлөв байдал

“Галзоо хан” ХХК нь Ашигт Малтмал Газрын Тосны Газраас 2022 оны 9 сарын 14-ний өдөр MV-021694 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан. Төслийн талбай дээр очиж ажиллахад одоогийн байдлаар ашиглалтын үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс уурхайн кемп байрлуулсан байна.

2.3 Төсөл хэрэгжих талбайн газрын гадарга


Далайн түвшнээс дээш 1250 м өргөгдсөн. Физик газар зүйн хувьд Дундад халхын болон дорнод Монголын талархаг хээрийн мужийн тэгш өндөрлөгийн тойрог, Хэрлэн голын өмнөд баруун урд талын нам уулсын тойргуудад тус тус хуваагдан оршино. Газар хөдлөлийн эрчим 7 балл. Сумын нутаг дэвсгэр нь дундаж ба нам уулс, тал хээрийн жижиг толгод бүхий гүвээрхэг, долгиорхог, тэгш тал газар, тэдгээрийн хоорондох нугархаг нам хотсуудаар тодорхойлогдоно. Тал хээрийн бүст орших учир хөрсний үржил шим харьцангуй муу, чийг бага учир газар тариалан, хадлангийн аж ахуй эрхлэх боломж хязгаарлагдмал. Дүүргийн талбайн баруун талын рельеф нь Хангай, Хэнтий уулсын завсрын дүр төрхтэй болдог. Өмнөд хэсэг нь тал хээрийн бүс нутгийн ландшафтын үндсэн дүр төрхтэй. Төсөл хэрэгжих талбайн газрын гадаргын өндөржилтийн зургийг ArcGis 10.5 программ ашиглан зураглахад Д.Т.Д 1360-1420 метрийн өндөрт өргөгдсөн байна.



Зураг 5 Газрын гадаргын өндөржилтийн зураг

2.4 Төсөл хэрэгжих талбайн газаргын налуу

Төв аймгийн Баян сум нь далайн түвшнээс дээш 1250 м өргөгдсөн. Сумын нутаг дэвсгэр нь дундаж ба нам уулс, тал хээрийн жижиг толгод бүхий гүвээрхэг, долгиорхог, тэгш тал газар, тэдгээрийн хоорондох нугархаг нам хотсууд оршино. Сумын хойд хэсгээ ууулын газрын гадаргн өндөршил нэмэгдэнэ. Урагшлах тусам газрын гадаргын өндөршилт багасна. Төслийн газрын гадаргын хувьд , тал хээрийн жижиг толгод бүхий гүвээрхэг гадаргуутай байна.




Зураг 6 Төсөл хэрэгжих талбайн налуужилтын зураг

Төсөл хэрэгжих талбайн газрын гадаргын налуужилтын зургийг ArcGis 10.5 программ ашиглан зураглахад Д.Т.Д 2.7-22.5 градусын налуужилттай байна.

2.5 Төслийн талбайн физик газарзүйн нөхцөл

Ордын дүүрэг нь Төв Монголын хагарлын дагуух нутаг дэвсгэрийн Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөт хэсэгт харьяалагдана. Энэ дүүргийн дунд зэргийн өндөрлөгтэй бэсрэг уулс нь идэгдэл хэрчигдэлд нилээд орсон эгц хажуу шовх оройтой, хадан гарш, гуу жалга ихтэй. Талбайн хойт, баруун хойт хэсгээр жижиг

толгодлог болон хөндий бүхий нам уулсын гадаргуу зонхилох бөгөөд тэдгээр нь ерөнхийдөө баруун, баруун хойш чиглэлд сунаж тогтсон байдаг Далайн төвшнээс дээш 1500-1700 м өргөгдсөн. Физик газар зүйн хувьд Хэнтийн нурууны захын уулсын мужид, Газар хөдлөлийн эрчим 7 балл. Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ




Зураг 7 Байгалын бүс бүслүүрийн зураг

толгод бүхий тал хээр, мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой.

Төсөл хэрэгжих талбайн байгалийн бүс бүслүүрийн тархалтын зургийг ArcGis 10.5 программ ашиглан зураглахад хээрийн бүсэд хамаарч байна.

2.6 Төслийн талбайн хөрсөн бүрхэвч

Төсөл хэрэгжих талбай нь хөрс газарзүйн мужлалаар Хангайн их мужийн хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүсийн мааньтын тойрогт хамаарна. Төслийн талбай орчим хөрсний тархалтын хувьд хээрийн хүрэн, хар хүрэн, хотос хонхор газар руугаа хужир мараалаг хөрс тархсан байна.



Зураг 8 Төслийн талбайн хөрсөн бүрхэвч

2.8 Нийгэм эдийн засаг

Төв аймгийн Баян сум нь анх 1924 онд Түшээт хан аймгийн Богдхаан уулын хошуу Авдар баян сум, Зогсоол, Жаргалант уулын хошуунд байгуулагдсан. 1956 онд төмөр замын Мааньт өртөөн дээр төвлөрсөн байна. Цант, Өгөөмөр, Цавчир гэсэн 3 багтай, 290,5 мянган га газар нутагтай.

Төсөл хэгэржих газрын орон нутгын хүн амзүйн мэдээлэл: Төв аймгийн Баян сум нь 2021 оны дүнгээр нийт 2256 хүн амтай бөгөөд үүний 54,8% буюу 1238 эрэгтэйчүүд, 45,2% буюу 1018 эмэгтэйчүүд байна.



График 1 Баян сумын хүн амын хүйсийн бүтэц

Баян суманд 2021 оны эцсийн байдлаар нийт 634 өрх айл бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 1,02 хувиар буюу 13 ширхгээр нэмэгдсэн байна. Баян сумын төрөлтийн тоо болон хүйсээр ангилан доорх графикт харуулсан байна. Үүнээс 2020 оны эцсийн байдлаар нийт төрөлт 44 бүртгэгдсэнээс 24 эрэгтэй, 20 эмэгтэй хүүхэд шинээр төрсөн байна.




График 2 Баян сумын төрөлтийн тоо, хүйсээр

Мал сүрэг: Малын бүтэц Сумын хэмжээнд 75361 толгой малтайгаас тэмээ 163 буюу 0.22 хувь, адуу 7394 буюу 9.81 хувь, үхэр 2827 буюу 3.75 хувь, хонь 39272 буюу 52.11 хувь, ямаа 25705 буюу 34.11 хувь байна.





График 3 Малын сүргийн бүтэц

Зам тээвэр: Баян сум нь зам тээврийн дэд бүтцийн хувьд аймгийн бусад сумдаас харьцангуй илүү бөгөөд сумын төвийг манай улсын төмөр замын гол шугам Улаанбаатар төмөр замын “Баян” өртөө, Азийн хөгжлийн сангийн хөрөнгөөр баригдсан босоо тэнхлэгийн Улаанбаатар, Чойр, Сайншандын чиглэлийн засмал зам дайран өнгөрдөг. Улаанбаатар хотоос 100 км, Төв аймгаас 85 км, Багахангай дүүргээс 12 км зайтай оршдог сум юм. Багууд хоорондоо шороон замаар холбогддог.

Ус хангамж: Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн гүний 2 худагтай. Энэ худаг нь сумын төвийн иргэдийн ундны усыг хангадаг. Энэ 2 худгийн ус нь шохойн чулуулгийн улмаас тунадас их хэмжээгээр үүсдэг бөгөөд шүүлтүүр тавьж цэвэршүүлэх шаардлагатай. Бэлчээрийн усан хангамжийн хувьд өрөмдлөгийн 26 худаг байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Галзоо хан” ХХК-ны Төв аймгийн Баян суман нутагт орших MV-021694 ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаартай “Мааньт-Уул” хайлуур жоншны ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаа хэрэгжсэнээр тухайн бүс тодорхой хэмжээгээр элэгдэлд орно. Элэгдэл эвдрэлд оруулах гол хүчин зүйл нь хүнд даацын машины хөдөлгөөн, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үеийн тоос тоосонцор, дуу чимээ зэрэг юм.



ТАНИХ ТЭМДЭГ

Төслийн талбай	Уурхайн кемп	Уурхайн нөөц	800 метрийн радиуст нөлөөлөл бага
Сайжруулсан шороон зам	Тэсрэх бодисын агуулах	Уурхайн овоолго	500 метрийн радиуст нөлөөлөл дунд
Түлшний агуулах	Баяжуулах	Уурхайн гол ам	300 метрийн радиуст нөлөөлөл их

Зураг 10 Нөлөөллийн эрчмийн зураг

Мөн төсөл хэрэгжсэнээр байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Агаарын чанар:

- Бүтээгдэхүүн тээвэрлэх үеийн машины утаа тортог, замын тоос үүсэх
- Хүдэр боловсруулах үед үүсэх тоосжилт

- Барилга байгууламжийн орчмын шимт хөрс элэгдэж эвдэрснээс ургамлын нөмрөг талхлагдсанаас тоосжилт үүсэх
- Хатуу хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүйгээс ялзарч муудан, үнэр орсноор агаар орчныг бохирдуулах зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- ✓ Машин техникийг тогтмол үзлэгт хамрагдуулж байх, янданд шүүлтүүр тавих
- ✓ Зам талбайг тогтмол усалж чийгшүүлж байх
- ✓ Ажилчдын амрах байр сууцны гадна талбайг зүлэгжүүлж тохижуулж агаарын чанарыг сайжруулах
- ✓ Хог хаягдлыг цаг тухай бүрд ачуулж, ангилах ялгаж байх
- ✓ Төсөл хэрэгжих бүхий хугацаанд агаарын тоос болон хорт бодисыг хэмжилтийн цэг бүр дээр тогтмол хийж байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой юм

Хөрсөн бүрхэвч: Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- ✚ Барилга байгууламжийн ойр орчмын шимт хөрс элэгдэж, эвдэрснээс ургамлан нөмрөг талхлагдах
- ✚ Ачиж тээвэрлэх үеийн машин техникийн хөдөлгөөнөөс хучилтгүй зам талбайн хөрс элэгдэж, эвдрэх
- ✚ Олон салаа зам гарган зорчих
- ✚ Машин техникийн эвдрэл гэмтлээс үүдэн тос, тослох материалын асгаралтаас хөрс, ус бохирдох
- ✚ Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- ✚ Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- ✓ Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис зэрэг барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын гадна талбайг цементлэх
- ✓ Олон салаа зам гаргахгүй байх, зам талбайн тэмдэгжүүлэлт хийх
- ✓ Уурхайн гадаад болон дотоод тээврийн замыг хатуу хучилттай болгох
- ✓ Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаях, цаг тухай бүрт ачуулах, ангилан ялгаж байх
- ✓ Цэвэрлэх байгууламж болон ариун цэврийн байгууламжийг байгаль ээлтэй технологийг сонгон ашиглах эдгээрийн эвдрэл гэмтлийг шалгаж байх
- ✓ Уурхайн машин техник төхөөрөмжийн үзлэг шинжилгээг тогтмол хийж байх

Гадаргын болон газрын доорх ус: “Мааньт- Уул” хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар ашиглах төслийн гидрогеологийн судалгаагаар уурхайн ашиглалтын талбайд гүний уст цэг илрээгүй байна. Мөн унд ахуйн усны хэрэгцээг хангахын тулд шинэ худаг гаргахаар төлөвлөсөн. Төслийн талбайн ойр орчимд гол горхи, булаг шанд зэрэг гадаргын усны эх үүсвэр байхгүй байна. Иймд төсөл хэрэгжих явцад байгалийн усны нөөц болон усны бохирдолд үзүүлэх нөлөөлөл байхгүй юм. Гэвч ахуйн бохир ус болон хог хаягдлыг зөв байршуулаагүй мөн орчны цэвэрлэгээ хийгээгүйн улмаас гадаргын болон хөрсний усыг тодорхой хэмжээгээр бохирдуулж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ:

- ✓ “Галзоо хан” ХХК нь цэвэрлэх байгууламж байгуулан шингэн хаягдлыг байгаль орчинд халгүй арга хэлбэрээр зайлуулах, дахин ашиглах арга хэмжээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хуулийн 2019 оны 05 сарын 02нд батлагдсан нэмэлт өөрчлөлтийг, Усны тухай хуулийн 3.1.32, 3.1.33, 25, MNS 4943:2015 стандарт, 2.2-2.4, 25 дугаар зүйлийн 25.1, 8 дугаар зүйл, зэргийг дагаж мөрдөнө ажиллахыг зөвлөж байна.

Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл: Ажиллагсдын ихэнх нь дуу чимээ ихтэй, температурын эрс өөрчлөлттэй нөхцөлд ажиллахаар байгаа тул мэргэжлээс шалтгаалах өвчлөлд хялбар өртөх магадлалтай юм. Түүнчлэн хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, зориулалтын ажлын нормт хувцасны хангалт, ашиглалтад анхааралтай хандаагүйгээс үйлдвэрлэлийн осолд өртөх магадлалтай байна. Байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ:

- ✓ Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хугацаанд хамрагдуулж байх
- ✓ Эрүүл ахуй аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг өдөр бүр өгч байх
- ✓ Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болон зориулалтын ажлын хувцсаар хангах
- ✓ Галын аюулгүй ажиллагаа болон гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах
- ✓ Ажилчдыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахин мөрдүүлэх тал дээр хяналт тавих

Ургамлан нөмрөг: Хүнд машин техникийн хөдөлгөөнөөр орчны ургамлан бүрхэвч алдагдах, ажиллагсад зориудын бус замаар явах, анхаарал болгоомжгүйгээс гал түймэр гарах зэрэг нь ургамлан нөмрөгт нөлөөлөн, түүний

төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах (хог ургамал ихсэх), зэрэг сөрөг нөлөөллүүд үүсч болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ:

- ✓ Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис зэрэг барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын гадна талбайг цементлэх
- ✓ Амрах байрнаас хоолны газар хүрэх зам гэх мэт явган хүний замыг нэг маршрутаар болгож цементлэн хашиж аль болох унаган ургамлыг нь гэмтээхгүй байх
- ✓ Гадна талбайг тохижуулах хашиж хамгаалах, тогтмол усалж арчилж байх
- ✓ Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын зэрэг барилга байгууламжид галын аюулгүй ажиллагааны буланг хийх ажилчдад хэрэглэх заавар зөвлөгөө санамжийг тогтмол өгөх, сургалт зохион байгуулах

Амьтны аймаг: Төслөөс амьтны аймагт нөлөөлөх шууд нөлөөлөл байхгүй. Төсөл хэрэгжих газар тээврийн хэрэгсэл, хүний хөдөлгөөн ихсэж, дуу чимээний нөлөөлөл зэргээс жижиг амьтад дайжих, амьдрах орчин хумигдсан. Харин ногоон байгууламжийг байгуулснаар төслийн ойр орчмын талбайд тыархах зарим амьтдад амьдрахад эерэг нөлөөлөл үзүүлж болох юм.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ:

- ✓ Хөрсийг зүй зохистой ашиглах, олон салаа зам гаргахгүй байх, тогтсон нэг замаар тээврийн хэрэгслүүдийг зорчуулах.
- ✓ Ховор амьтадыг устахаас хамгаалж өөр газар шилжүүлэх болон биотехникийн арга хэмжээ авах талаар судалгаа хийх, шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгууллагын зөвлөмж авч хэрэгжүүлэх
- ✓ Уулын малталт, овоолгыг ан амьтанд аюулгүй байхаар байрлуулах
- ✓ Биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах

Нийгэм эдийн засаг: Төслийн үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага ба аливаа болзошгүй нөлөөлөл нь хүний анхаарал, болгоомжгүй, хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаална. Төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмийн албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг улс болон орон нутгийн төсвийн санд оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр орон нутагт шинэ ажлын байр нэмэгдэх боломжтой юм.

**“ГАЛЗОО ХАН” ХХК-ИЙН ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН НУТАГТ ОРШИХ “МААНЬТ УУЛ”
ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Аливаа төслийн үйл ажиллагаанаас тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал, нийгэм, эдийн засаг болон хүн амын амьдрах орчинд хэрхэн нөлөөлөх, тэдгээр нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимшил зэргийг тогтооход магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргыг өргөн хэрэглэдэг. Энэ арга нь экспертүүдийн гаргасан үнэлэлт, дүгнэлтүүдийг магадлалын онолд тулгуурлан боловсруудах замаар хэрэгждэг. Магадлан жагсаах арга нь нөлөөлөх зүйл байна, байхгүй гэсэн зарчмаар үнэлэх бөгөөд нөлөөлөл байвал “х”-ээр тэмдэглэнэ. Ингэхдээ уг үнэлгээнд оролцсон шинжээч, судлаачдын дүгнэлтийг үндэслэн 2 төрлийн жагсаалт гаргасан. Нөлөөллийн хэлбэр нь үргэлжлэх хугацаа, эрчмийг илрүүлэхэд зориулагдсан бөгөөд нөлөөлөл нь “шууд”, “шууд бус”, “буцаж нөлөөлөх”, “буцалтгүй нөлөөлөх”, давхардах эсэхийг тодруулах, хугацааны хувьд “богино хугацааны”, “урт хугацааны”, эрчмийн хувьд “бага зэрэг”, “дунд”, “хүчтэй” гэхчилэн ангилсан магадлах жагсаах аргаар тодорхойлсон. Доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 6 Төслийн болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөл			Хугацаа		Давтамж		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Сулавтар нөлөөлөх	Дунд зураг	Хүчтэй нөлөөлөх
Биологийн төрөл зүйлийн оршин амьдрах нөхцөл											
1	Газрын доорх усны чанар		x		x			x	x		
2	Газрын доорх усны нөөц		x			x		x	x		
3	Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x	x		x		
4	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x								
Байгаль орчны чанарын өөрчлөлт											
5	Усны чанар, хэмжээ		x		x		x			x	
6	Агаарын бохирдол		x		x			x	x		
7	Хөрсний бохирдол		x			x	x		x		
8	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл		x		x			x		x	
9	Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	x							x		
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл											
10	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+				+		+		+	

**“ГАЛЗОО ХАН” ХХК-ИЙН ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН НУТАГТ ОРШИХ “МААНЬТ УУЛ”
ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

11	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх										
12	Хүн, амын орлого нэмэгдэх	+				+		+		+	
13	Хүн амын тоо өөрчлөгдөх										
Эдийн засаг, байгаль орчин											
14	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+		+		+		+		+	
15	Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+		+			+
16	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		+			+		+	+		
17	Ажлын байр нэмэгдэх	+				+	+			+	
18	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+		+		+		
19	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x		x		x			x	
Бусад нөлөөлөл											
20	Хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих		x		x		x		x		
21	Нөлөөллийн тоо ширхэг	Сөрөг	2	9		6	3	5	4	7	3
		Эерэг	6	1	1	1	6	2	5	2	4

Тайлбар: “+” эерэг, “x” сөрөг

Хүснэгт 7 Нөлөөллийн эрчим, цар хүрээ, шинж чанараар ангилсан байдал

Шууд нөлөөллийн тоо: 8	
Эерэг нөлөөлөл нь: 6	Сөрөг нөлөөлөл нь: 2
<ul style="list-style-type: none"> - Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх - Хүн, амын орлого нэмэгдэх - Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх - Орон нутгийн орлого нэмэгдэх - Ажлын байр нэмэгдэх - Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх 	<ul style="list-style-type: none"> - Хөрсний элэгдэл, эвдрэл - Дуу чимээ, шуугианы нөлөө
Шууд бус нөлөөллийн тоо: 5	
Эерэг нөлөөлөл нь: 1	Сөрөг нөлөөлөл нь: 4
<ul style="list-style-type: none"> - Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох 	<ul style="list-style-type: none"> - Газрын доорх усны чанар - Усны чанар, хэмжээ - Агаарын бохирдол - Хөрсний бохирдол
Өөрөө зохицуулагдах нөлөөллийн тоо: 1	
Эерэг нөлөөлөл нь: 1	Сөрөг нөлөөлөл нь:
<ul style="list-style-type: none"> - Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх 	
Богино хугацааны нөлөөллийн тоо: 3	

“ГАЛЗОО ХАН” ХХК-ИЙН ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН НУТАГТ ОРШИХ “МААНЬТ УУЛ”
ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сөрөг нөлөөлөл нь: 2	Эерэг нөлөөлөл нь: 1
<ul style="list-style-type: none"> - Усны чанар, хэмжээ - Агаарын бохирдол 	<ul style="list-style-type: none"> - Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
Урт хугацааны нөлөөллийн тоо : 9	
Сөрөг нөлөөлөл нь: 3	Эерэг нөлөөлөл нь: 6
<ul style="list-style-type: none"> - Газрын доорх усны чанар - Хөрсний элэгдэл, эвдрэл - Хөрсний бохирдол 	<ul style="list-style-type: none"> - Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх - Хүн, амын орлого нэмэгдэх - Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх - Орон нутгийн орлого нэмэгдэх - Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох - Ажлын байр нэмэгдэх
Буцах нөлөөллийн тоо: 4	
Сөрөг нөлөөлөл нь: 2	Эерэг нөлөөлөл нь: 2
<ul style="list-style-type: none"> - Хөрсний элэгдэл, эвдрэл - Усны чанар, хэмжээ 	<ul style="list-style-type: none"> - Ажлын байр нэмэгдэх - Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
Буцалтгүй нөлөөллийн тоо: 9	
Сөрөг нөлөөлөл нь: 4	Эерэг нөлөөлөл нь: 5
<ul style="list-style-type: none"> - Газрын доорх усны чанар - Газрын доорх усны нөөц - Агаарын бохирдол 	<ul style="list-style-type: none"> - Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх - Хүн, амын орлого нэмэгдэх - Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх - Орон нутгийн орлого нэмэгдэх - Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
Сулавтар нөлөөллийн тоо: 9	
Сөрөг нөлөөлөл нь: 7	Эерэг нөлөөлөл нь: 2
Эрчимтэй нөлөөллийн тоо : 1	
Сөрөг нөлөөлөл нь: 0	Эерэг нөлөөлөл нь: 1
	<ul style="list-style-type: none"> - Орон нутгийн орлого нэмэгдэх

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр тусгасан.

“Галзоо хан” ХХК нь Төв аймгийн Баян сумын нутагт орших “Мааньт Уул” хайлуур жоншны ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглах төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, мөн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримтлан боловсруулсан.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2024 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 3,000.0 мян/төг зарцуулахаар төсөвлөв. Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дугаар сарын 01-ний дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг 12 сарын 30-ны дотор холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ	БОМТ-ийн нийт зардал /мян.төг/,
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	500.0
Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	500.0
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	600.0
Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	350.0
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	680.0
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	300.0
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	70.0
Нийт	3,000.0

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн акт барим бичиг
Агаар										
1	Тоног төхөөрөмж ажиллах	Тоног төхөөрөмж ашиглаж байх үеийн тоос	Машин тоног төхөөрөмжөөс гарах утааг хянах тогтмол үзлэг хийх	Төслийн талбайд	-	100.0	1	100.0	Үйл ажиллаганы турш	-MNS 0017-2-3-16:1988. Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам.
2	Тээвэрлэлтийн үед	уурхайн тээвэрлэлтийн үед тоос шороо босох	Олон салаа зам гаргахгүй байхад анхаарал хяналт тавих	Төслийн талбайд	--	-	1	-	Үйл ажиллаганы турши	- MNS 3384-1982. Байгаль орчны хамгаалал. Агаар мандал. Сорьц авахад тавигдах ерөнхий шаардлага. - MNS 3384:1982. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, - MNS0017-2-5-11:1988. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, -MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга -Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих
Хөрсөнд										
3			Шаардлагагүй газар ухаж	Төслийн талбайд	-	100.0	-	100.0		

“ГАЛЗОО ХАН” ХХК-ИЙН ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН НУТАГТ ОРШИХ “МААНЬТ УУЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	Ашиглалтын үед	Хөрсний унган төрхийг алдагдуулах	сэндийчэхгүй байх							Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль -MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 4006:1987 Хөрс. MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга -MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга
4			Төслийн үйл ажиллагааны үед ашигласан тос, тослох материалыг ил задгай хаяхгүй байх		100.0	-	-	100.0	Үйл ажиллагааны турш	
5			Автомашин хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах тэмдэг тавих	Төслийн талбайд		-	-	-	-	
Усны нөөц, усны чанарт										
6	Ашиглалтын үед	Ус бохирдох, усны нөөц буурах	Ажилчидад усыг ариг гамтай хэрэглэх, хамгаалах тухай сургалт зохион байгуулах	Уурхайн нийт ажилчидад	100.0	-	-	100.0	1 удаа	

“ГАЛЗОО ХАН” ХХК-ИЙН ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН НУТАГТ ОРШИХ “МААНЬТ УУЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

7			Ажилчдын унд ахуйн усанд ашиглаж байгаа гүний худагаас дээж авч шинжилгээ хийлгэж,	Ажилчдын байрны хүрээнд	-	-	-	-	Орчны хяналт шинжилгээний зардалд	
Амьтны аймаг, ургамлан нөмрөг										
8	Үйл ажиллг ааны үед	Үйл ажиллагаа явуулсантай амьтны нөөц хомсдох, ухсан нүх шуудуунд мал амьтан унах	Үйл ажилгааны явцад үссэн нүх шуудууг бөглөх	Төслийн талбайд	100.0	-	-	100.0	Үйл ажиллагааны турш	
9		Хог хаягдалыг ил задгай хаяж хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор амьтад үржих, хордох нөхцөл бүрдүүлэхгүй байх	Хог хаягдлыг ангилан ялгах хогын сав байршуулах	Төслийн талбайд	-	-	-	-	Хог хаягдлын зардалд	
Нийт 500.0										

БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян,төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүй баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	2024 онд биологын болон техникийн нөхөн сэргээлт хийгдэхгүй							“Байгаль орчныг хамгаалах тухай” “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” MNS5915:2008MNS5916:2008 MNS5917:2008
2	Биологийн нөхөн сэргээлт								
Нийт 0,0 сая.төг									

БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал,төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
Нөхөн сэргээлт 2024 хөтөлбөрийн хүрээнд эвдэрсэн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх	Тербум мод үндэсний хөдөлгөөн” хөтөлбөрийн хүрээнд төслийн талбайн ойр орчим мод тарих	100ш	5.0	500.0	2024он	
Нийт				500.0төг		

БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

БҮЛЭГ 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал (мян\төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Уурхайд орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг тоосны сарилтай уялдуулан тэмдэглэж ажиллах	Уурхайн кемп	2	100.0	200.0	Үйл ажиллагааны турш	
	Галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Уурхайн бүх ажилчдад	1	100.0	100.0	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх	Үйл ажиллагааны турш	1	100.0	100.0	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
	Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн багаж хэрэгсэл байрлуулах.	Уурхайн кемп	1	100.0	100.0	Үйл ажиллагааны турш	
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах,	Үйл ажиллагааны турш	2	50.0	100.0	1 болон 2-р улиралд	
Нийт			600.0 төг				

БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг, стандарт аргачлал
Ахуйн болон хатуу хог хаягдал	Жижиг хогын сав тавих	Уурхайн кемп	-	50.0	3	150.0	-	-Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344:2011 -Хог хаягдлын тухай хууль
	Хог хаягдлыг цуглуулах савыг агаар сайн нэвтэрдэг байхаар хийх	Уурхайн кемп	-	100.0	1	100.0	Үйл ажиллагааны үед	
	Орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулах.	Үйл ажиллагааны турш	-	100.0	1	100.0	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
Нийт						350.0 төг		

БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж 2024 он	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Хөрсний бохирдол								
1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 2 цэг сонгох /Уурхайн кемп орчим, уурхайн ухаш/	Хагас жил тутамд	Жилд 2 удаа	15.0	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1 жил /15.0/ НИЙТ 120,0 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж - 15.0 төг,	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох	2 цэгт /Засварын цех, ШТС/	Хагас жил тутамд	Жилд 2 удаа	20.0	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1 жил х 20,0 Нийт 160,0 хүнд металлын шинжилгээ	

**“ГАЛЗОО ХАН” ХХК-ИЙН ТӨВ АЙМГИЙН БАЯН СУМЫН НУТАГТ ОРШИХ “МААНЬТ УУЛ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ БОЛОН ДАЛД
УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

							э 1 дээж- 20.0 төг/	
Усны хяналт шинжилгээ								
2	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Унд ахуйн усыг хангаж буй уснаас	2024 он	Жилд 2 удаа	40.0	40.0*2 удаа x 1жил НИЙТ 80.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3	Усны түвшин усны ундарга нөөц	Ус ашиглалтаас, зарцуулалтаа с газар доорх усны горим өөрчлөгдөх	Гүний худгийн ус, Гол	2024 он				
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2024 ОНЫ ЗАРДЛЫН ДҮН							680.0	

**БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРЛАГА
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		2024 он					
		I- улирал	II- улирал	III-улирал	IV-улирал		
Ажилчдад байгаль орчныг хамгаалах талаар сургалт зохион байгуулах	100.0	-	+	-	-	Байгаль орчны мэргэжилтэн	-MNS 4968: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн журам гарган ажилчдад мөрдүүлэн ажиллах.	Үйл ажиллагааны зардлаар	+	+	+	+	Уурхайн дарга, хаб	
Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардлаар	+		+		Захирал	
Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	-	+	+	+	+	Захирал	
Байгаль орчны аутид хийлгэх	100.0	+				Захирал	
Гал түймрээс урьдчилан сэргийлэх багаж хэрэгсэл байрлуулах.	-	+				Захирал	
Нийгмийн хариуцлагын хүрээнд багын иргэдэд үйл ажиллагааг дэмжих үүднээс тусламж өгөх	200.0					Захирал	
Нийт						300.0 төг	

**БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЯНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ
НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ**

БОМТ түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэрүүд	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах	Зохион байгуулах газар
Бомт-ийн биелэлтийг оршин суугчдад тайлагнах					
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Төв аймгийн Баян сумын засаг захиргааны байгууллагад танилцуулж, хэлэлцүүлнэ.	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумдын засаг захиргаанд хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлт	БОМТ-ний хэрэгжилтийн явцад орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон оршин суугчдад танилцуулна.	Сумын засаг захиргааны удирдлага болон байгаль орчны байгууллагын санал, шүүмжийг хүлээн авч шийдвэрлэх	Төв аймгийн Баян сумын Засаг захиргааны байранд
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Төв аймгийн Баян сумын нутгийн оршин суугчдад танилцуулж хэлэлцүүлнэ.	Нутгийн оршин суугчдад БОМТ-ний биелэлтийг тайлагнах	БОМТ-ний биелэлт		Оршин суугчдын санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх	
Нийт			70.0 төг		